



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

# БАТЛАМЖ

Бат-Өлзий сумын Засаг даргын өмнө багийн Засаг даргаар томилогдохдоо Миний бие багийнхаа хөгжлийг эрчимтэйгээр урагшлуулж, ард иргэдийнхээ эрүүл саруул, ажил орлоготой, ая тухтай амьдралыг цогцлоон бий болгохын төлөө өөрийн оюун билиг, мэдлэг чадвар, сэтгэл зүтгэлээ дайчлан зориулж, төр засгийн бодлого шийдвэрийг тууштай, шуурхай, шударга, хариуцлагатайгаар хэрэгжүүлэх үүднээс доорхи үүрэг, зарчмуудыг мөрдлөг болгон ажиллахаа батламжилж байна.

1. Багийн Засаг даргын хувьд хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ төрийн хуулийг чандлан сахиж, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон ажиллана.

2. Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж ажиллана.

3. Сахилга хариуцлагыг эрс сайжруулан төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдлээс ангид иргэдэд нээлттэй, ил тод, шударгаар үйлчилнэ.

4. Багийн нутаг дэвсгэрийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, төвийн гудамж, хашааны эмх цэгцийг сайжруулан, нийгмийн дэг журмыг ханган ажиллана.

5. Монгол Улсын Төсвийн тухай хуулийг чанд мөрдөж, өөрийн багийн иргэд, байгууллагаас сумын төсөвт оруулах бүх төрлийн татвар хураамжийн төлөвлөгөөг бүрэн биелүүлнэ.

6. Багийн иргэдийн нийтлэг эрх ашиг сонирхлыг илэрхийлж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор айл, өрх бүрт тогтмол хүрч ажиллана.

7. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчид, Засаг дарга болон холбогдох мэргэжилтнүүдийн өгөгдсөн үүрэг, даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, үр дүнг тогтмол тайлагнах, дэмжлэг туслалцаа авч ажиллана.

8. Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан, хууль зөрчиж албан тушаалаа урвуулан ашигласан, авлига, хээл хахууль авсан, ёс суртахууны доголдол гаргасан, архидан согтуурсан зэрэг тохиолдолд Засаг даргын үүрэгт ажлаас шууд татгалзах, зохих хууль тогтоомжийн дагуу шийтгэл, хариуцлага хүлээхэд татгалзах зүйлгүй.

9. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Тэр бум” мод тарих аяны хүрээнд суманд 1 сая мод тарих ажилд идэвх санаачилгатай ажиллана.

10. Энэхүү батламжаар хүлээсэн үүргийн биелэлтийг хагас, бүтэн жилээр сумын Засаг дарга болон Багийн иргэдэд тайлагнана.

Батламж гарын үсэг зурсан өдрөөс эхлэн багийн Засаг даргын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болох хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

УЛИАСТАЙ 6 ДУГААР БАГИЙН  
ЗАСАГ ДАРГА *Дэшигүйтва* Д.ДЭМИДДАГВА